



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ЗОХИЦУУЛАЛТ 2023

NOVOTEL 2023.12.01


“Мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын төслийн танилцуулга

А.УРАНЧИМЭГ

ХХЗХ-ны ЗБХГ-ын ахлах мэргэжилтэн

www.crc.gov.mn

МЭДЭЭЛЛИЙН СҮЛЖЭЭ – ДИЖИТАЛ ЭДИЙН ЗАСАГ



МЭДЭЭЛЛИЙН СҮЛЖЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ЗОРИЛГО



Дижитал эдийн засгийг дэмжих дэд бүтэц



Нийгэм, эдийн засгийн бүх салбарт колабрэйшн



Мэдээллийн сүлжээний үр ашигтай, нээлттэй зарчим



Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, аюулгүй, чанартай, найдвартай үйлчилгээ



Мэдээллийн сүлжээ ашиглан үйлчилгээ эрхлэгчийн нөхцөл, шаардлага, зохицуулалт

ОЛОН УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

ЗОХИЦУУЛАЛТ 2023

NOVOTEL 2023.12.01



Мьянмар	Тусгай зөвшөөрөл
Саудын Араб	Тусгай зөвшөөрөл
Кайманы Арлууд	Тусгай зөвшөөрөл
Этиоп	Тусгай зөвшөөрөл
Энэтхэг	Тусгай зөвшөөрөл



Data center

Индонез	Интернет үйлчилгээ үзүүлэгч болон үүлэн үйлчилгээ үзүүлэгчдийг багтаасан хувийн цахим үйлчилгээ эрхлэгчийн бүртгэл хийдэг
Тайланд	Тусгай зөвшөөрөл олгодог бөгөөд Мэдээлэл хамгаалах хуулийг дагаж мөрддөг
Вьетнам	Техникийн шалгууруудыг агуулсан удирдамж гаргасан бөгөөд энэхүү шалгууруудын биелэлт нь баталгаажуулалт болдог
Австрали	Хувийн нууцын тухай хуулийг дагаж мөрддөг
Энэтхэг	Тусгай зөвшөөрөл/бүртгэл
Их Британи	Мэдээлэл хамгаалах тухай хуулиар зохицуулдаг



Энэтхэг	CDN бүртгэл
Герман	Холбооны мэдээллийн аюулгүй байдлын албаны тухай хуулийн хүрээнд гуравдагч талаар аудит хийлгэдэг
Бразил	Мультимедиа холбооны үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй
Австрали	Харилцаа холбооны тухай хуулийн дагуу зохицуулагддаг
Өмнөд Солонгос	Харилцаа холбооны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээнд хамаардаггүй бөгөөд суурь дамжуулах үйлчилгээнд хамаарч зохицуулдаг.
Кени	Контент үйлчилгээ үзүүлэгчийн тусгай зөвшөөрөл авдаг

МЭДЭЭЛЛИЙН СҮЛЖЭЭ АШИГЛАХ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫН ТӨСЛИЙН БҮТЭЦ

ЗОХИЦУУЛАЛТ 2023

NOVOTEL 2023.12.01

I. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нөхцөл, шаардлагын зорилго, хамрах хүрээг тусгасан.

II. МЭДЭЭЛЛИЙН СҮЛЖЭЭНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНДСЭН ЗАРЧИМ

Мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх үйл ажиллагаанд хамаарах үйлчилгээний тодорхойлолт, түүний баримтлах зарчмыг тусгасан.

III. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

Мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргах хуулийн этгээд нь энэхүү нөхцөлийг бүрдүүлсэн байх юм. Ерөнхий нөхцөлд бизнесийн болон аюулгүй, найдвартай системийн төлөвлөгөөтэй, мэргэшсэн мэргэжилтэнтэй, IPv6 технологийг нэвтрүүлсэн, үндэсний интернэт харилцан холболтын төвд холбогдсон байх зэрэг тусгагдсан.

IV. МЭДЭЭЛЛИЙН СҮЛЖЭЭНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэхэд үйл ажиллагаанд энэхүү шаардлагыг дагаж мөрдөх юм. Ерөнхий шаардлагад хэрэглэгч болон бусад үйлчилгээ эрхлэгчид хүндрэл учруулахгүй, шударга үйл ажиллагаа эрхлэх, мэдээллээр хангаж ажиллах, техникийн шаардлагыг хангах, яаралтай үед ашиглах нөөцийг зохион байгуулах, бүртгэл тэмдэглэл хөтлөх зэрэг асуудлыг тусгасан.

V. МЭДЭЭЛЛИЙН СҮЛЖЭЭНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУСГАЙ ШААРДЛАГА

Интернэт харилцан холболтын үйлчилгээ (IXP), тусгай дугаар ашиглан үзүүлж буй мессежийн үйлчилгээ (SMS HUB) эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү тусгай шаардлагыг хангаж ажиллах юм.

VI. СҮЛЖЭЭНД ХОЛБОГ ДОХОД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Харилцаа холбооны сүлжээнд холбогдох зарчим болон сүлжээ, үйлчилгээтэй холбоотой тайланг ирүүлэх тухай тусгасан.

VII. ХЭРЭГЛЭГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Мэдээллийн сүлжээ ашиглан үзүүлж буй үйлчилгээ нь энэхүү шаардлагыг хангасан байх юм. Үйлчилгээний мэдээллийг ойлгомжтой хэлбэрээр байршуулах, хэрэглэгчийн гомдлыг шуурхай шийдвэрлэх, давагдашгүй хүчин зүйл болон онцгой нөхцөл байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг дотоод журамд тусгасан байх зэрэг багтсан болно.

VIII. НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫН БИЕЛЭЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ

Зохицуулах хороо нь энэхүү нөхцөл, шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах тухай тусгасан.

1. НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫН ЗОРИЛГО

2. ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧИЙН ДАГАЖ МӨРДӨХ БАРИМТ БИЧИГ

3. БУСАД ХАРИЛЦАА

1.1. Энэхүү нөхцөл, шаардлагын зорилго нь Харилцаа холбооны тухай хуулийн 191 дүгээр зүйлийн 191.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийн 9.3-т заасан мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх үйл ажиллагаанд тавих нөхцөл, шаардлагыг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавихтай холбогдох харилцааг зохицуулахад оршино.

1.2. Мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх өргөдөл гаргагч болон тусгай зөвшөөрөл эзэмшигч (цаашид "үйлчилгээ эрхлэгч" гэх) нь Монгол Улсын олон улсын гэрээ, Зөвшөөрлийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль болон бусад хууль, тогтоомж, салбарын бодлогын баримт бичиг, Монгол Улсын үндэсний стандарт болон Зохицуулах хорооноос баталсан норматив, зохицуулалтын баримт бичиг, журам, шийдвэрийг дагаж мөрдөнө.

1.3. Энэхүү нөхцөл, шаардлагад тусгаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, нөхцөл, шаардлага болон Зохицуулах хорооноос баталсан "Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалтын нөхцөл, шаардлага"-аар зохицуулна.

ХОЁР. МЭДЭЭЛЛИЙН СҮЛЖЭЭНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНДСЭН ЗАРЧИМ

ЗОХИЦУУЛАЛТ 2023

NOVOTEL 2023.12.01

1. НЭЭЛТТЭЙ, ИЖИЛ ТЭГШ НӨХЦӨЛ
2. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 19' 1
3. ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 8.1 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙН 9.3
4. ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛИЙН 12.3
5. ӨГӨГДӨЛ ХАМГААЛАХ ДЭД БҮЦИЙН ҮЭ БҮРТГЭХ
6. ХУУЛЬ БУС КОНТЕНТ

2.1. Мэдээллийн сүлжээг интернэтэд суурилсан үйлчилгээг нээлттэй, ижил тэгш нөхцөлөөр дамжуулах, интернэтийн үйлчилгээний чанарын шаардлагыг хангасан байдлаар зохион байгуулна.

2.2. Харилцаа холбооны тухай хуулийн 191 дүгээр зүйлийн 191.1 дэх хэсэгт заасан Мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх үйл ажиллагаанд цахилгаан холбооны сүлжээнд холболт хийж тусгай дугаар ашиглан хэрэглэгчдэд мессежийн үйлчилгээг дамжуулан хүргэх үйлчилгээ (цаашид мессежийн үйлчилгээ гэх, SMS HUB), интернэт харилцан холболтын үйлчилгээ (IXP), өгөгдөл хадгалах дэд бүтцийн үйлчилгээ (Data center) болон контент түгээх сүлжээ үйлчилгээ (CDN) хамаарна.

2.3. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт хамаарах “Мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагаанд цахилгаан холбооны сүлжээнд холболт хийж хэрэглэгчдэд тусгай дугаар ашиглан мессежийн үйлчилгээг дамжуулан хүргэх үйлчилгээ (цаашид мессежийн үйлчилгээ гэх, SMS HUB), интернэт харилцан холболтын үйлчилгээ (IXP) хамаарна.

2.4. Өгөгдөл хадгалах дэд бүтцийн үйлчилгээ (Data center) болон контент түгээх сүлжээ үйлчилгээ (CDN) эрхлэх этгээд нь Харилцаа холбооны тухай хуулийн 12.3 дахь хэсэгт заасны дагуу Зохицуулах хороонд бүртгүүлнэ.

2.5. Энэхүү нөхцөл, шаардлагын 2.4-т заасан өгөгдөл хадгалах дэд бүтцийн үйлчилгээ эрхлэгч нь ашиг олох зорилгоор хэрэглэгчид үйлчилгээ үзүүлдэг Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд байна.

2.6. Энэхүү нөхцөл, шаардлагын 2.3 болон 2.4-т заасан үйлчилгээ эрхлэгч нь Монгол Улсын холбогдох хууль, эрх зүйн баримт бичгийг зөрчсөн агуулга бүхий контентийн Монгол Улсаас хандах хандалтыг эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрийг үндэслэн Зохицуулах хорооноос шаардсаны дагуу хязгаарлана.

ГУРАВ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

ЗОХИЦУУЛАЛТ 2023

NOVOTEL 2023.12.01

1. САНХҮҮ-ЭДИЙН ЗАСАГ-БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ
2. МЭРГЭЖЛИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАМЖ:
3. ТЕХНИКИЙН ЧАДАВХ



3.1. Мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авах өргөдөл гаргахад дараах нөхцөлийг бүрдүүлсэн байна:

3.1.1. дунд хугацааны буюу 5 жилийн бизнес төлөвлөгөө боловсруулж, баталсан байх бөгөөд уг төлөвлөгөөнд дараах мэдээллийг тусгасан байна:

3.1.1.1. эрхлэх үйлчилгээний зах зээлийн талаарх мэдээлэл, зорилтот зах зээлд нэвтрэх болон үйлчилгээг өргөжүүлэх бизнесийн загвар;

3.1.1.2. хөрөнгө оруулалтын тооцоолол; /шаардлагатай техник, тоног төхөөрөмж, ашиглах технологи, тэдгээрийн санхүүжилтийн эх үүсвэр, хөрөнгө оруулалтын үр ашгийн тооцоо гэх мэт/;

3.1.1.3. зах зээлд нэвтрэх үнийн бодлого, үйлчилгээний үнэ тарифын төсөөлөл.



3.1.2. системийн аюулгүй байдал, холболтын найдвартай ажиллагаа, хэрэглэгчийн нууцлал, мэдээллийн аюулгүй байдлыг хангах боломжтой системийн бүтэц зохион байгуулалтыг төлөвлөсөн байх;

3.1.3. хууль зөрчсөн контентыг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтны дүгнэлт, шийдвэрийн дагуу хязгаарлах техникийн боломжийг бүрдүүлсэн байх;

3.1.4. үйлчилгээний найдвартай ажиллагааг хангах зорилгоор сүлжээний удирдлага, хяналтын нэгдсэн системтэй байх;

3.1.5. мэдээллийн сүлжээний техник, тоног төхөөрөмжийн суурилуулалт, ашиглалт үйлчилгээний талаар мэдлэг, туршлага бүхий мэргэжлийн 2-оос доошгүй мэргэшсэн ажилтантай байх;



3.1.6. ашиглах техник, тоног төхөөрөмж нь холбогдох стандарт, техникийн зохицуулалт болон аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан, итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагын тохирлын гэрчилгээтэй байх;

3.1.7. АйПи хаягийн 4 болон 6-р хувилбарыг (IPv4, IPv6) хослуулан ашиглах техникийн боломжийг бүрдүүлсэн байх;

3.1.8. Монгол Улсын интернэтийн харилцан холболтод холбогдох, Монгол Улсад ажиллаж буй бусад сүлжээний төхөөрөмжүүдтэй харилцан уялдаж ажиллах, сүлжээнд холбогдох боломжтой байх.



ДӨРӨВ. МЭДЭЭЛЛИЙН СҮЛЖЭЭНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

3-р ХИЦУУЛАЛТ 2023

NOVOTEL 2023.12.01

1. ХЭРЭГЛЭГЧИЙН ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХАМГААЛАХ

2. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛӨӨР ОЛГОГДСОН ЭРХ, ҮҮРЭГ

3. ХЭРЭГЛЭГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ЗӨРЧИХГҮЙ, ЭРХ ТЭГШ,
ШУДАРГА БАЙХ

4. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ,
ҮЗЛЭГ, ХЭМЖИЛТИЙГ ХИЙХ ЖУРАМ, ЗААВАР

5. ГЭМТЭЛ СААТЛЫН ҮЕИЙН ЖУРАМ, ПРОЦЕСС

6. ТЕХНИКИЙН ӨРӨӨ СТАНДАРТ ХАНГАСАН БАЙХ

7. ЦАХИЛГААНЫ ХОЁРООС ДООШГҮЙ ЭХ ҮҮСВЭР

8. КИБЕР ХАЛДЛАГА, ЗӨРЧЛӨӨС СЭРГИЙЛЭХ

9. ХЯНАЛТЫН СИСТЕМИЙН МЭДЭЭЛЭЛ-3 САР

4.1.1. хэрэглэгчийн хувийн мэдээллийг зориулалтын бусаар ашиглахгүй, хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад дамжуулахгүй байх.

4.1.2. тусгай зөвшөөрлөөр олгогдсон эрх, үүрэг, хариуцлагаа бусдад шилжүүлэх, үндсэн үйл ажиллагаа, эрх үүргийг өөрчилсөн аливаа хэлбэрийн гэрээ байгуулахгүй.

4.1.3. үйл ажиллагаа нь хэрэглэгчдийн эрх ашгийг зөрчихгүй, хэт нэг талыг барихгүй, эрх тэгш, шударга байх, бусад үйлчилгээ эрхлэгчдэд хаалт, саад учруулахгүй байна.

4.1.4. үндсэн болон нөөц техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж, тэдгээрийн үзлэг, хэмжилтийг тогтсон хуваарийн дагуу хийх, хэмжилтийн үр дүнг тухай бүр бүртгэлжүүлж ажиллах бөгөөд үзлэг, хэмжилтийг хийх журам, заавар, технологийн картыг боловсруулан баталж үйл ажиллагаандаа мөрдөнө.

4.1.5. гэмтэл саатлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон журамтай, процесстой байна.

4.1.6. техникийн өрөө нь ашиглаж буй техник, тоног төхөөрөмжийн техникийн баримт бичигт заасан орчны стандарт шаардлага (температур, чийгшил, агааржуулалт г.м)-ыг хангасан байна.

4.1.7. үндсэн техник, тоног төхөөрөмжийн тасралтгүй үйл ажиллагааг хангах зорилгоор цахилгааны хоёроос доошгүй эх үүсвэрт холбогдсон байх, зай тэжээлийн нөөц эх үүсвэр (генератор, салхи болон нарны зай тэжээл гэх мэт)-ийг зохион байгуулсан байна.

4.1.8. кибер халдлага, зөрчлийн үед хэрэгжүүлэх арга хэмжээний талаар чадавхитай хүний нөөцийг бүрдүүлж, хагас жил тутамд эрсдэлийн үнэлгээ хийж, холбогдох арга хэмжээ авч ажиллана.

4.1.9. сүлжээний хяналтын нэгдсэн системийн мэдээллийг 3-аас доошгүй сарын хугацаанд архивлана.

ДӨРӨВ. МЭДЭЭЛЛИЙН СҮЛЖЭЭНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

ЗОХИЦУУЛАЛТ 2023

NOVOTEL 2023.12.01

10. МОНГОЛ УЛСЫН ЭТАЛОН ЦАГТАЙ ХОЛБОГДОХ

11. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ УРЬДЧИЛАН МЭДЭГДЭХ

12. СТАТИСТИК ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ

13. БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ, ҮНЭ ТАРИФЫН ӨӨРЧЛӨЛТ

14. (ХАБЭА)-Н ДҮРЭМ

15. ГАМШГИЙН ҮЕД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

16. ТАЙЛАН, МЭДЭЭ

4.1.10. Зохицуулах хорооноос зохион байгуулсан сүлжээний цагийн нэгдсэн серверээр дамжуулан Монгол Улсын эталон цагтай холбогдоно.

4.1.11. техник тоног төхөөрөмжийг шинээр суурилуулах, өргөтгөх, шинэчлэх технологийн шинэчлэл нь хэрэглэгчийн үйлчилгээ болон бусад үйлчилгээ эрхлэгчдэд сөргөөр нөлөөлөх бол хэрэглэгч, үйлчилгээ эрхлэгч болон Зохицуулах хороонд урьдчилан мэдэгдэнэ.

4.1.12. статистик тайлан, мэдээллийг холбогдох маягтын дагуу хагас жил тутам Зохицуулах хороонд ирүүлнэ.

4.1.13. бизнес төлөвлөгөө, үнэ тарифт өөрчлөлт оруулах тохиолдолд мэдээллийг холбогдох үндэслэл, тайлбарын хамт Зохицуулах хороонд ирүүлнэ.

4.1.14. инженер, техникийн ажилтнуудад дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй (ХАБЭА)-н дүрэмтэй байх ба аюулгүй ажиллах нөхцөлийг хангаж ажиллана.

4.1.15. гамшгийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гамшгаас хамгаалах холбогдох эрх бүхий байгууллага болон Зохицуулах хорооны төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллана.

4.1.16. Зохицуулах хорооноос шаардсан тайлан, мэдээ, мэдээллийг тухай бүр заасан хугацаанд гаргаж ирүүлнэ.

ТАВ. МЭДЭЭЛЛИЙН СҮЛЖЭЭНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУСГАЙ ШААРДЛАГА

ЗӨХИЦУУЛАЛТ 2023

NOVOTEL 2023.12.01

1. ИНТЕРНЭТ ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ (IXP)

А. сүлжээний ачааллын менежмент

эрх бүхий байгууллагын хуульд нийцсэн шийдвэрийг хэрэгжүүлэх

найдвартай, аюулгүй байдлыг хангах

internet network congestion

Б. харилцан холболтын төв хооронд Гбит/с-ээс багагүй

интернэтийн үйлчилгээ эрхлэгч хооронд 10 Гбит/с-ээс

багагүй

2. ТУСГАЙ ДУГААР АШИГЛАН МЕССЕЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ

холболтын байгууламж, төлбөр тооцоо, хяналтын систем

спам мессеж

байнгын хэмжилт, тогтмол хяналт хийх

ачааллыг хуваарилах горимыг дэмжих

аюулгүй байдлыг хангах

5.1.Мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд интернэт харилцан холболтын үйлчилгээ (IXP) үзүүлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах тусгай шаардлагыг хангаж ажиллана:

5.1.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах тохиолдолд интернэтэд суурилсан үйлчилгээг хаах (block), ялгаварлах (discriminate), өөрчлөх (alter), хязгаарлах (restrict), саад учруулах (interfere), доройтуулах (degrade) зэрэг арга хэмжээ (цаашид сүлжээний ачааллын менежмент гэх)-г авч хэрэгжүүлж болно. Үүнд:

5.1.1.1.холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын хуульд нийцсэн шийдвэрийг хэрэгжүүлэх;

5.1.1.2. интернэтийн найдвартай, аюулгүй байдлыг хангах;

5.1.1.3.интернэт дамжуулж буй сүлжээний түгжрэл (internet network congestion)-ийг оновчтой болгох.

5.1.2.интернэт протокол ашигласан харилцан холболтын үйлчилгээ эрхлэгч нь интернэтийн харилцан холболтын төв хооронд 100 Гбит/с, интернэтийн харилцан холболтын төв ба интернэтийн үйлчилгээ эрхлэгч хооронд 10 Гбит/с-ээс доошгүй багтаамжтай холбох шугамтай байна.

5.2.Мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд тусгай дугаар ашиглан мессежийн үйлчилгээ үзүүлэх (цаашид мессежийн үйлчилгээ гэх) тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах техникийн тусгай шаардлагыг хангаж ажиллана:

5.2.1.холболтын байгууламж (softswitch, gateway, router), төлбөр тооцооны систем, зай тэжээлийн төхөөрөмж болон тэдгээрийн хяналтын системтэй байна;

5.2.2.спам мессежийг илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх техник, тоног төхөөрөмжийн боломжийг бүрдүүлсэн байна;

5.2.3.үйлчилгээний чанар, стандарт болон норматив шаардлагыг ханган ажиллах зорилгын хүрээнд техник, тоног төхөөрөмжид байнгын хэмжилт, тогтмол хяналт хийх хэмжүүрийн багаж, хэрэгсэл эсхүл программ хангамжаар хангагдсан байна;

5.2.4.роутинг нь актив стандабй болон ачааллыг хуваарилах горимыг дэмждэг байна;

5.2.5.хэрэглэгчийн холболт, системийн хандалт аюулгүй байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг урьдчилан батлуулсан байна.

ЗУРГАА. СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХОД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

ЗОХИЦУУЛАЛТ 2023

NOVOTEL 2023.12.01

6.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь **Харилцаа холбооны бусад сүлжээнд холбогдох, харилцан холболт хийхэд** Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, 22 дугаар зүйл болон Зохицуулах хорооноос баталсан холбогдох журмыг баримталж, гэрээ байгуулан ажиллана.

6.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Зохицуулах хорооноос шаардсаны дагуу өөрийн үйлчилгээг хэрэглэгчид хүргэх сүлжээний төлөвлөлт, бүтэц, архитектур, бусад үйлчилгээний сүлжээ, системтэй харилцан холбогдсон байдал, техникийн үзүүлэлт, үйлчилгээний чанар, гомдол маргаан, ачааллын судалгааны тайлан мэдээг ирүүлнэ.

ДОЛОО. ХЭРЭГЛЭГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

ЗОХИЦУУЛАЛТ 2023

NOVOTEL 2023.12.01

1. ЖИШИГ ГЭРЭЭ, ҮНЭ ТАРИФЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ
2. ШААРДЛАГА ХАНГАХГҮЙ ТӨГСГӨЛИЙН ТӨХӨӨРӨМЖ
3. ХЭРЭГЛЭГЧИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ
4. ХЭРЭГЛЭГЧИЙН БҮРТГЭЛ, ЭРХИЙН ФУНК
5. ХЭРЭГЛЭГЧИЙН ГЭРЭЭ
6. ХЭРЭГЛЭГЧИД УРЬДЧИЛАН МЭДЭГ ДЭХ
7. ХЭРЭГЛЭГЧИЙГ ХОХИРООХООС СЭРГИЙЛЭХ

7.1.Хэрэглэгчид үзүүлэх үйлчилгээний нөхцөл, шаардлага, хамрах хүрээ, жишиг гэрээ, үнэ тарифын талаарх мэдээллийг ойлгомжтой хэлбэрээр өөрийн веб сайт болон боломжит бусад сувгуудаар мэдээлнэ.

7.2. Стандартын шаардлага хангахгүй төгсгөлийн төхөөрөмжийг холбох, мэдээллийг аюулгүй байдлын стандартад нийцээгүй холболт ашиглан үйлчилгээ үзүүлэхээс татгалзах эрхтэй.

7.3.Хэрэглэгчийн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх журамтай байх ба өргөдөл, гомдлыг түргэн шуурхай, үл ялгаварлах зарчим баримталж шийдвэрлэнэ.

7.4.Хэрэглэгчийн бүртгэл (хэрэглэгчийг регистрийн дугаараар, байгууллагын хэрэглэгчийг тухайн байгууллагын регистрийн дугаар болон тухайн эзэмшигч иргэний регистрийн дугаар, овог, нэрээр бүртгэдэг байх)-ийг хийх, үйлчилгээний эрхтэй холбоотой функцүүдтэй байна.

7.5. Хэрэглэгчтэй гэрээ байгуулахдаа хэрэглэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх , хэт нэг талыг барьсан зохицуулалт тусгахаас зайлсхийж, эрх тэгш, шударга байх, гэрээний чөлөөт байдлын зарчмыг баримтална.

7.6. Техник, технологийн шинэчлэл хийх, урьдчилан сэргийлэх үзлэг, үйлчилгээ хийх зэрэг тохиолдолд хэрэглэгчид урьдчилан мэдэгдэнэ.

7.7.Давагдашгүй хүчин зүйл болон онцгой нөхцөл байдлын улмаас үйлчилгээ үзүүлэх боломжгүй болох, тусгай зөвшөөрөл нь дуусгавар болох, түдгэлзэх, хүчингүй болох эсхүл дампуурах зэрэг тохиолдолд хэрэглэгчийг хохироохгүй байх арга хэмжээг авах, энэ талаарх харилцааг үйлчилгээний журам, нөхцөл шаардлагадаа заавал тусгасан байна.

8.1. Зохицуулах хороо нь энэхүү нөхцөл, шаардлагын хэрэгжилтэд дараах байдлаар хяналт тавьж ажиллана:

8.1.1. төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх;

8.1.2. үйлчилгээ эрхлэгчийн ирүүлсэн статистик болон бусад тайлан мэдээллийг хянах, шалгах;

8.1.3. иргэн, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын дагуу мэдээлэл гаргуулан авч, хяналт, шалгалтыг тухай бүрт хийх;

8.1.4. үйлчилгээ эрхлэгчтэй байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг жил бүр дүгнэх.



**АНХААРАЛ
ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА**